

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Булган АЗЗА” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/3/НА-СТА-ТБОӨААН

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын саналдүгнэлт

БУЛГАН АЗЗА ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Э.ПҮРЭВДЭМБЭРЭЛ ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Булган АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Булган АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газрын газар хоорондын хэлэлцээрийн дагуу хөнгөлөлттэй зээлээр барьсан өргөтгөлийн ажил дуусаж, ашиглаж эхэлсэн боловч хөрөнгийг бүртгээгүй, зээлийн төлөлтийн талаарх шийдвэрийг ирүүлээгүй байна.

Бусад мэдээлэл

Тус компани нь зам засвар арчлалтын ажлыг гүйцэтгэхээр Зам Тээврийн Хөгжлийн Яам, Төрийн Өмчийн Бодлого зохицуулалтын газартай гэрээ байгуулан ажилласан.

Гэрээний дагуу 2021 онд 1,728,718.5 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй ажиллаж 1,519,876.8 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгэж төлөвлөгөөг 87,9 хувиар биелүүлж 9,086.3 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Төсвийн төлбөрт 156,895.2 мянган төгрөг төлөхөөр төлөвлөснөөс 219,702.9 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 140.0 хувиар буюу 62,807.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлж ААНОАТатварт 908,6 мянган төгрөг төлөхөөр ,4,088.8 мянган төгрөгийн ногдол ашгийн өглөг үүсгэсэн байна.

Удирдлагын зардлыг нийт борлуулалтын 16,2 хувиар буюу 280,960.6 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба 241,377.5 мянган төгрөгийн зардал гарган зардлыг 39,583.1 мянган төгрөгөөр бууруулан ажилласан.

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудитхийсэн санхүүгийн байдлыг тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	677,070,962.84	695,485,960.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	25,709,342.35	142,891,742.67
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	5,854,056.17	2,007,933.22
31110	Төгрөг	5,854,056.17	
31140	Касс арилжааны банк	19,855,286.48	140,883,809.45
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	19,855,286.18	140,883,809.45
31213	Арилжааны банк дахь харилцах	19,855,286.48	140,883,809.45
33	АВЛАГА	394,649,376.75	301,521,336.62
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,459,455.09	1,012,955.04
33401	Дансны авлага /ТӨҮГ/	393,189,921.66	300,508,381.58
34	УРЬДЧИЛГАА	0.00	97,731,699.51
34600	Урьдчилж гарсан зардал		97,731,699.51
35	БАРАА МАТЕРИАЛ	256,712,243.44	153,341,181.71
354	Хангамжийн материал	256,712,243.44	153,341,181.71
35430	Сэлбэг хэрэгсэл	41,629,040.76	
35440	Түлш, шатах тослох материал	2,588,243.62	
35450	Барилгын засварын материал	149,691,704.49	
35470	Бусад хангамжийн материал	59,011,969.57	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,325,348,472.73	-
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	565,211,312.00	
373	Урт хугацаат зээл	565,211,312.00	565,211,312.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,325,348,472.72	1,235,243,055.21
392	Биет хөрөнгө	1,022,228,472.72	932,123,055.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	548,279,970.86	548,279,970.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	54,715,249.31	67,738,364.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	658,869,665.60	129,090,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	608,613,705.67	62,821,923.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,508,271,208.92	1,308,854,120.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	1,043,836,428.56	943,874,053.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,961,604.44	53,337,277.01

“Булган АЗЗА” ТӨХК-ийн 2021оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39208	Хуримтлагдсан элэгдэл		
		36,988,593.56	33,004,471.91
393	Биет бус хөрөнгө		
		303,120,000.00	303,120,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		
		305,120,000.00	305,120,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
		2,000,000.00	2,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,002,419,435.57</u>	<u>1,930,729,015.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
		721,078,519.46	598,099,263.54
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
		155,867,207.46	32,887,951.54
413	Өглөг		
		155,867,207.46	32,887,951.57
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
		2,835,564.26	777,850.00
4136	Бусад өглөг		
		153,031,643.20	32,110,101.53
41361	Байгууллагад төлөх өглөг		
		1,145,939.99	0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		
		1,340,734.77	0
41363	Татварын өглөг /ТӨҮГ/		
		50,544,968.44	28,021,266.53
41365	Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/		
		-	4,088,835.00
41366	Дансны өглөг /ТӨҮГ/		
		100,000,000.00	0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
		565,211,312.00	565,211,312.00
422	Урт хугацаат зээл		
		565,211,312.00	565,211,312.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,281,340,916.07</u>	<u>1,332,629,752.17</u>
51	Засгийн газрын хувь оролцоо		
		1,281,340,916.07	1,332,629,752.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		1,095,236,019.14	1,098,247,184.14
51101	Өмч: - төрийн		
		1,095,236,019.14	1,098,247,184.14
512	Хуримтлагдсан үр дүн		
		(520,779,828.15)	(517,745,553.43)
51210	Өмнөх үеийн үр дүн		
		(488,190,594.11)	
51220	Тайлант үеийн үр дүн		
		(32,589,234.04)	8,177,671.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
		712,028,121.46	752,128,121.46
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
		(5,143,396.38)	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,002,419,435.53</u>	<u>1,930,729,015.71</u>

2.2 Аудитхийсэндэлгэрэнгүйорлогынтайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	908,630.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	908,630.00
110	Орлогын албан татвар		908,630.00
120009	Бусад орлого	3,514,650.92	22,807,919.41

“Булган АЗЗА” ТӨХК-ийн 2021оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	1,800,066,330.77	1,497,068,905.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	1,294,046,749.18	1,045,378,537.82
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,618,243.92	302,098,067.93
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	203,957,262.89	189,738,437.45
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	11,296,056.36	11,034,600.71
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	23,751,857.75	7,033,656.34
210813	Бусад зардал /ТӨҮГ/	85,613,066.92	94,291,373.43
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	217,505,222.63	163,313,917.57
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	217,505,222.63	163,313,917.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(32,589,234.04)	8,177,671.09
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(32,589,234.04)	9,086,301.09

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,095,236,019.14	712,028,121.46	-525,923,224.53	1,281,340,916.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,095,236,019.14	712,028,121.46	-525,923,224.53	1,281,340,916.07
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,095,236,019.14	712,028,121.46	-525,923,224.53	1,281,340,916.07
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,095,236,019.14	712,028,121.46	-525,923,224.53	1,281,340,916.07

“Булган АЗЗА” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		40,100,000.00		40,100,000.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	3,011,165.00			3,011,165.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			8,177,671.09	8,177,671.09
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,098,247,184.14	752,128,121.46	-517,745,553.44	1,332,629,752.16

2.4 Аудитхийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,769,147,742.16	1,765,325,486.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,769,147,742.16	1,765,325,486.00
110	Орлогын албан татвар	2,769,147,742.16	1,765,325,486.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,769,147,742.16	1,765,325,486.00
110002	Үйл ажиллагааны орлого	2,769,147,742.16	1,765,325,486.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,646,337,248.72	1,548,143,085.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,646,337,248.72	1,548,143,085.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,646,337,248.72	1,548,143,085.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339,136,240.60	326,941,493.60
210101	Үндсэн цалин	339,136,240.60	326,941,493.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,606,997.68	120,490,101.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,000.00	80,000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	100,000.00	80,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,636,809,821.18	627,835,068.37
210402	Тээвэр, шатахуун		55,000.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	1,636,809,821.18	627,780,068.37
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	511,684,189.26	472,796,422.60
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	191,866,141.92	150,242,960.74
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/		1,589,100.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	319,818,047.34	320,964,361.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(98,690,000.00)	(100,000,000.00)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН	400,000,000.00	

“Булган АЗЗА” ТӨХК-ийн 2021оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ОРЛОГЫН ДҮН (4)			
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	400,000,000.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	498,690,000.00	100,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	498,690,000.00	100,000,000.00
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	496,600,000.00	100,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(98,690,000.00)	(100,000,000.00)
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	2,090,000.00	
250005	Төлсөн ногдол ашиг	2,090,000.00	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,090,000.00	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	24,120,493.44	117,182,400.02
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,588,849.21	25,709,342.65
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,709,342.65	142,891,742.67

2.5 Техник, эдийнзасгийнүзүүлэлт, зорилтоттүвшнийгүйцэтгэл

Д/д	Эдийнзасгийнүндсэнүзүүлэлт	мян/төгрөг				
		2021он			зөрүү	
		Төлөвлөгөө неаттэй	Төлөвлөгөө неатгүй	Гүйцэтгэл	хувиар	дүнгээр
1	Нийторлого	1,901,591.5	1,728,718.7	1,519,876.8	87.9	208,841.90
	Үүнээс: Улсынчанартай ЗЗА	1,199,180.0	1,090,162.8	1,090,162.8	100.0	-
	Бусад	702,411.5	638,555.9	429,714.0	67.3	208,841.90
2	Нийтзардал	1,865,723.9	1,692,851.3	1,510,790.5	89.2	182,060.80
	Үүгээс: Удирдлагынзардал	280,960.6	280,960.6	241,377.5	85.9	39,583.10
3	Татварынөмнөхашиг	35,867.4	35,867.4	9,086.3	25.3	26,781.10
4	Цэвэррашиг/ алдагдал/	32,280.6	32,280.6	8,177.7	25.3	24,102.90
5	Төсвийнтөлбөрт	156,895.2	156,895.2	219,702.9	140.0	(62,807.70)
6	Төрийнөмчийнноогдолашиг	4,842.0	4,842.0	4,088.8	84.4	753.20
7	Ажиллагсдынтоо	49	49	42	85.7	7.00
8	Цалингийнсан	437,876.4	437,876.4	421,606.3	96.3	16,270.10
9	Нэгажилтныдундажцалин	744.6	744.6	836.5	112.3	(91.90)

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажилагаа

“Булган АЗЗА” ТӨХК-ний зорилго нь Орчин үеийн дэвшилтэт техник технологийг Олон улсын болон улсын чанартай замын засвар арчлалтыг гүйцэтгэх замаар хүнийэрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд ээлтэй, харилцагчдаа дээдэлсэн, хөдөлгөөний аюулгүй байдал болон зорчигчдын ая тухтай аялах нөхцлийг бүрэн хангахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг авто зам, зам байгууламжийг барих, засварлах гэж тодорхойлжээ. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төрээмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тус компани нь Булган аймаг байгуулагдсаны дараа жил 1939 онд гэрээгээр хүмүүс гарган 2 үхэр тэрэгтэйгээр машин явж болохгүй Хөвсгөл чиглэлийн Чачиртын гүүрийн ойролцоох намгархаг газарт шургааг дэвсэн шороо хийж эхэлсэнээр Булган аймагт Замын байгууллага үүсэж хөгжих анхны эхлэл тавигдсан билээ. Булган аймгийн Зам анги 1941 оны 6 сард 5 орон тоотой, 5 тн-ын даацтай Полу маркын автомашинтай одоогийн Булган хотын нэгдүгээр хорооны харъяад байсан ард Пүрэвийн хашаа байшинг худалдан авч /Хуучнаар Гал командын байр / үйл ажиллагаагаа явуулж байсан.

1986 онд Зам барилга ашиглалтын контор болон өргөжсөн. 1993 онд Зам барилгын “Эрдэнэ суварга” ХХК, Зам барилга ашиглалтын компани гэсэн 2 хэсэгт хуваагдсан. 1997 онд хоёр компани эргэн нэгдэж Зам барилгын “Эрдэнэ суварга” ХК болсон.

2005 оны 4-р сард Төрийн өмчийн хорооны тогтоолоор Төрийн мэдлийн 63%-ийн хувьцаанд хөрөнгө, боловсон хүчнийг салган Хөвсгөл, Орхон аймгийн замын байгууллагыг нэгтгэн “Булган- АЗЗАН” ТӨХК болсон.

Монгол улсын засгийн газрын 2006 оны 173 тоот тогтоолоор “Булган-АЗЗАН” ТӨХК-ийг өөрчлөн “Булган АЗЗА” ТӨХК, “Хөвсгөл АЗЗА” ТӨХК, “Орхон АЗЗА” ТӨХК гэсэн гурван бие даасан компани болсон.

“Булган АЗЗА” ТӨХК нь 82 жилийн хугацаанд зам засвар,барилга угсралтын ажлыг гүйцэтгэх замаар тээврийн хэрэгслийнхөдөлгөөний аюулгүй байдал болон зорчигчдын тав тухтай аялахнөхцлийг ханган ажиллаж байна.

Тус компани нь 204,1км асфальт бетон хучилттай зам, 38,76кмхайрган хучилттай зам, 145,64км ердийн болон сайжруулсан хөрсөнзам бүгд 388,5км Олон улсын болон улсын чанартай замын бэлэнбайдлыг хариуцсан ажилладаг.

Үүнд чиглэлээр нь: А0901 дугаартай Булган-Дашинчилэнчиглэлийн 71,5 м, А0902 дугаартай Булган-Мөрөн чиглэлийн 158 км,А1002 дугаартай Эрдэнэт-Булган чиглэлийн 24,1 км, А13 дугаартайХутаг-Өндөр-Тэшиг-Улсын хил чиглэлийн 134,9 км зам хариуцдагаасгадна Эгийн гүүр, Гуртын гүүр, Орхоны гүүр, орон нутгийн чанартайХялганатын гүүр, Хануйн гүүр хариуцдаг.

Өнөөдрийн байдлаар үйлдвэрлэл явуулах хүчин чадлаанэмэгдүүлэн 22 тээврийн хэрэгсэл , 26 механизм, 46 техник тоногтөхөөрөмжтэй Зам засварлах, барих нөхцөлийг бүрдүүлэн ЗТХЯ-тайбайгуулсан гэрээний дагуу хариуцсан Олон улсын болон улсынчиглэлийн замын засвар арчлалтын ажлыг чанарын өндөр түвшиндхийж гүйцэтгэхийн зэрэгцээ аймаг орон нутгуудад зарлагдсан тендерторолцон цаг хугацаанд нь хийж хүлээлгэн өгч, зорилтод түвшиньтөлөвлөгөөгөө биелүүлэн ажиллаж байна.

Компанийн эрхэм зорилго, алсын харааг хэрэгжүүлэх ажлынхүрээнд зам засвар арчлалтын шинэ техник технологи нэвтрүүлэхажлыг улсын хэмжээнд анх удаагаа “Хүчитгэсэн суурьболовсруулалт”-ын ажлыг 2014 онд, Тэмдэглэгээний ажилд

“Евростандартын дагуу авто замын будаг”-ийг нэвтрүүлэх ажлыг 2016 онд, “Элс болон давсны хольцыг цацах төхөөрөмж”-ийг 2018 онд тус нэвтрүүлсэн.

Манай компани 2021 онд 37 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийт ажиллагсдын 75 хувь нь 35 дээш насны, 35,2% нь дээд, 55% нь бүрэн дунд, 10% нь тусгай дун мэргэжилтэй, 60 хувь нь замын салбарт 10-аас дээш жил ажилласан ажил мэргэжлийн хувьд мэргэшсэн ажиллагсадтай авто замын засвар, арчлалтын ажлыг технологийн дагуу зам, гүүрийн байнгын хэвийн байдлыг ханган үйлдвэрлэлийн ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн ажиллаж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь заалтуудтай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 9 хүнтэй томилсон байна. “Булган АЗЗА” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 30,000.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Эрчим хүчний яам, ТӨБЗГ-аас хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, орон тоо болон цалин хөлсийг нэмэгдүүлээгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн тэтгэврийн даатгал-ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “9.5” гэснийг “8.5” гэж, тэтгэврийн даатгал-даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “9.5” гэснийг “8.5” гэж, шимтгэлийн дүн-ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “12.7” гэснийг “11.7” гэж, шимтгэлийн дүн-

даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсөн.

3.3 Нягтланбодохбүртгэлийнбодлого

“Булган АЗЗА” ТӨҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	25,709.3	142,891.7	-117,182.4
Авлага	394,649.3	301,521.3	93,128.0
Урьдчилгаа			
Бараа материал	256,712.2	153,341.2	103,371.0
Урьдчилж гарсан зардал	0	97,731.6	-97,731.6
Үндсэн хөрөнгө	1,325,348.5	1,235,243.0	90,105.5
Нийт хөрөнгө	2,002,419.4	1,930,729.0	71,690.4
Өр төлбөр	721,078.5	598,099.3	122,979.2
Эздийн өмч	1281340.9	1,332,629.7	-51288.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,002,419.4	1,930,729.0	71,690.4

“Булган АЗЗА” ТӨҮГ-ын санхүүгийн тайлангаар 695,485.9 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, 1,235,243.0 мянган төгрөгийн эргэлтйн бус хөрөнгөтэй нийт хөрөнгийн хэмжээ 1,930,729.0 мянган төгрөг байна. Төрийн өмч 1,098,247.1 мянган төгрөг байна.

Мөнгөн хөрөнгө

2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71,690.4 мянган төгрөгөөр буюу 3,6 хувиар буурсан байна.

Тайлант оны эхэнд мөнгөн хөрөнгө 25,709.3 мянган төгрөг байсан ба оны эцэст 142,891.7 мянган төгрөг болж мөнгөн хөрөнгө 117,182.4 мянган төгрөгөөр өссөн.

Тайлангийн хугацааны эцэст касс дахь бэлэн мөнгө 2,007.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бэлэн мөнгөний үлдэгдлийг жилийн эцсээр тоолж баталгаажуулсан байна.

Авлага

“Булган АЗЗА” ТӨХК-ийн банкин дахь 140,883.7 мянган төгрөгийн үлдэгдэлийн 140,763.1 мянган төгрөг ХААН банкинд, 19.0 мянган төгрөг Хас банкинд, 101,6 мянган төгрөг Кридет банкинд тус бүр байршиж байна.

Авлага 394,649.3 мянган төгрөг байсан ба оны эцэст авлага 301,521.3 мянган төгрөг болж авлагыг 23,6 хувиар буюу 93,128.0 төгрөгөөр бууруулсан.

Авлагын үлдэгдэлд дансны авлага 12,161.9 мянган төгрөг, ажилчдаас авах авлага 1,012.9 мянган төгрөг, бусад авлаг 67,272.0 мянган төгрөг, замын сангаас авах авлага 100,248.1

2,438.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тавилга эд хогшлоос тоног төхөөрөмжид шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны 573, 761, 174,173, 167,154 дугаар тогтоолуудаар нийт 772,127.6 мянган төгрөгийн өртөгтэй, 772,127.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэйтээврийн хэрэгсэл, 10,706.7 мянган төгрөгийн өртөгтэй, 10,706.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй тоног төхөөрөмж, 5 853.9 мянган төгрөгийн өртөгтэй, 5,853.9 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй тавилга эд хогшил, 300,0 мянган төгрөгийн өртөгтэй, 300,0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй биет бус хөрөнгийг актласан байна.

Тайлангийн хугацааны эцэст 2021 оны 11 сарын 25-ны өдрийн А/30 тушаалаар үндсэн хөрөнгийн тооллогыг хийж баталгаажуулсан байна.

Өглөг

Богино хугацаат өглөг оны эхэнд 155,867.2 мянган төгрөг байсан бол оны эцэст 32,887.9 мянган төгрөг болж өглөгийг 79 хувиар буюу 122,979.0 мянган төгрөгөөр бууруулсан. Өглөгийн ихэнх хувийг татварын өглөг эзэлж байна.

Мөн 2009 онд Зам тээврийн яамны тушаал,ТӨХорооны тогтоолоор Кувейтын сангийн зээлээр бэлтгэсэн 17 нэр төрлийн машин тоног төхөөрөмжийн 565,211.3 мянган төгрөгийн урт хугацаат зээл дансанд бүртгэлтэй байдаг.Тэр үед ирсэн техникүүд нь одоо элэгдлийн хугацаа дуусч эхнээсээ актанд орж байна.

Зардал өртөг

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт компанийн тайлант хугацаанд гарсан өртөг, зардлыг ашиглалт, засвар, үйлчилгээ, ерөнхий удирдлага, борлуулалт маркетинг гэсэн өртгийн төвүүдэд аккруэл сууриар бодитой, үнэн зөв тооцож, тайлант хугацаанд нь зохистой ангилж, хуваарилж бүртгэх, үйл ажиллагааны бусад зардлыг аккруэл сууриар зөв, тооцож бүртгэхээр заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Борлуулалтын өртөг өмнөх онтой харьцуулахад 53,429.9 төгрөгөөр нэмэгдсэн нь түлш, ус, элэгдэл, нийгмийн даатгалын шимтгэлийн гэх зэрэг зардлын өсөлтөөс шалтгаалсан байна. Өмнөх оноос борлуулалт, маркетингийн зардал 99,138.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь борлуулалтын шимтгэл өсөлтөөс, ерөнхий ба удирдлагын зардал 261.4 мянган төгрөгөөр хасагдсан нь ЗГ-ын 43-р тогтоолтой холбоотой.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртгийг үйлдвэрлэлийн үе шатны аргаар тооцож бүртгэх ба ашиглалтын болон засвар үйлчилгээний зардал гэж ангилах бөгөөд үйлдвэрлэлийн зардлыг хамруулдаг байна. Харин үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлууд өртөгт хуваарилагдахгүй зардлууд байна. Эдгээрийг НББ-ийн бодлогын баримт бичигт тодорхой тусгасан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Булган АЗЗА” ТӨҮЗ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Д/Д	Эдийнзасгийн үндсэн үзүүлэлт	2021 он			мян/төгрөг зөрүү	
		Төлөвлөгөө нөөттэй	Төлөвлөгөөн өөртэй	Гүйцэтгэл	хувиар	дүнгээр
1	Нийторлого	1,901,591.5	1,728,718.7	1,519,876.8	87.9	208,841.90
	Үүнээс: Улсынчанартай АЗЗА	1,199,180.0	1,090,162.8	1,090,162.8	100.0	-
	Бусад	702,411.5	638,555.9	429,714.0	67.3	208,841.90
2	Нийт зардал	1,865,723.9	1,692,851.3	1,510,790.5	89.2	182,060.80
	Үүгээс: Удирдлагын зардал	280,960.6	280,960.6	241,377.5	85.9	39,583.10
3	Татварын өмнөх ашиг	35,867.4	35,867.4	9,086.3	25.3	26,781.10
4	Цэвэр ашиг/ алдагдал/	32,280.6	32,280.6	8,177.7	25.3	24,102.90
5	Төсвийн төлбөрт	156,895.2	156,895.2	219,702.9	140.0	(62,807.70)
6	Төрийн өмчийн ноогдолашиг	4,842.0	4,842.0	4,088.8	84.4	753.20
7	Ажиллагсдын тоо	49	49	42	85.7	7.00
8	Цалингийн сан	437,876.4	437,876.4	421,606.3	96.3	16,270.10
9	Нэг ажилтны дундаж цалин	744.6	744.6	836.5	112.3	(91.90)

Тус компани нь зам засвар арчлалтын ажлыг гүйцэтгэхээр Зам Тээврийн Хөгжлийн Яам, Төрийн Өмчийн Бодлого зохицуулалтын газартай гэрээ байгуулсан ажилласан. Гэрээний дагуу 2021 онд 1,728,718.5 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй ажиллаж 1,519,876.8 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгэж төлөвлөгөөг 87,9 хувиар биелүүлж 9,086.3 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Төсвийн төлбөрт 156,895.2 мянган төгрөг төлөхөөр төлөвлөсөнөөс 219,702.9 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 140.0 хувиар буюу 62,807.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлж ААНОАТ-т варт 908,6 мянган төгрөг, Төрийн өмчийн ноогдол ашигт 4,088.8 мянган төгрөг төвлөхөөр байна.

ТУЗ-өөр хэлцүүлэн ТӨХорооны 2020 оны 12 дугаар сарын 08-ны 619 дугаар тогтоолоор Булган АЗЗА ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,728,718.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,692,851.3 мянган төгрөгөөр, 32,280.6 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд энэ онд төлөвлөгөө гаргаагүй орлого зарлагагүй болно.

Гүйцэтгэлээр 1,519,876.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,510,790.5 мянган төгрөгийн зардал гарган, 9,086.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,519,876.8 мянган төгрөг болж төлөвлөснөөс 208,841.9 төгрөг буюу 13,7 хувиар тасарсан зам тээврийн яамнаас багасгаж баталсан, тендер авч чадаагүй зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,510,790.5 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 182,060.8 мянган төгрөг буюу 11.9 хувиар дутуугүйцэтгэлтэй байна. Энэ нь орлогын төлөвлөгөө дутуу батлагдаж ирсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө батлуулаагүй ажил хийгдээгүй.

Тайлант онд цэвэр ашиг 9,086.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 26,781.1 мянган төгрөгөөр дутуу байгаа орон нутгийн замын төлөвлөгөө тасарсан нь нөлөөлж байна.

Тайлант онд төсвөөс гадуур зардал гараагүй байна.

Үйл ажиллагааны бус орлого 22,807.9 мянган төгрөг олсон байна. Энэ нь дуудлага худалдаагаар олсон орлого болно.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зардал, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бэйкер тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбар ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 21-ны 18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн үед мөрдөгдөж байсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байсан хэдий ч 2019-2021 онд шинэчлэгдсэн хууль, журам, стандартын өөрчлөлтийг тусгаж шинэчлээгүй байна.

Тус компанийн 2021 оны 1-р сарын 26-ны өдрийн А/04 тоот тушаалаар Дотоод хяналт шалгалтын комисс байгуулсан боловч байгууллагын дотоод хяналтын комисс тайлант онд шалгалтын ажлын төлөвлөгөө боловсруулж шалгасан материал бидэнд ирүүлээгүй. Харин ЗТХЯ-наас 2019-2020 онд шалгалт хийж шилэн данс, өр авлагын харьцаа, барагдуулалт, анхан шатны баримтжуулалт, цалин бодолт зэргийг хянаж, санхүүгийн үйл ажиллагааг НББОУС-ын дагуу хөтөлж, тайланг хуулийн хугацаанд гаргаж зөвлөмжүүдийг өгч байсан байна.

2021 оны зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд дотоод аудит хийгээгүй, албан тушаалын тодорхойлолтод заасан зарим чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

ЗТХЯ-наас өгсөн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар тэдний гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Булган АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсөвлөсөн төсвийн орлогоос сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын төлөвлөсөн дүнгээс 1,901,591.5 мянган төгрөгөөс 1,0 хувиар буюу 19,015.9 төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ачхолбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган АЗЗА ТӨХК нь тайлантонд нийт 1,519,876.8 мянган төгрөгийн 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,519,876.8 мянган төгрөгийн 168 мэдээллийг мэдээлж, тоон мэдээлэлгүй 2 мэдээллийг хоцроон байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж байх, үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлж хариуцлага тооцох зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин анхан шатны баримтыг хүчин төгөлдөр баримтаар хөтлөөгүй, ТУЗ-аас баталсан их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй бараа материал /сэлбэг/ худалдан авсан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5, 13.6 дахь заалт, Сангийн сайдын 2017 онд баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” гэсэн заалттай нийцээгүй байна.

6.Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 41.9 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс зөвлөмж 100.0 хувийн биелэлттэй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7,815.6 мянган төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт, 607,396.6 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, тэг төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс акт 88,3 хувь, албан шаардлага 100 хувь, зөвлөмж.100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	6	7 815,6	6	7 222,6	6	592,9	88,3
Албан шаардлага	7	607,396.6	7	607,396.6			100
Зөвлөмж	3		3				100
Нийт дүн	16	615,212.2	16	614,619.2	6	596,9	

7.Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгийн тооцоолол, бүртгэл тайлагнал, урьдчилж орсон орлогын бүртгэл, олон жилийн насжилттай бараа материалын бодит үнэ цэнээр бүртгэсэн эсэхийг дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 32,058.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7,574.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 800.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21,848.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,835.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 24,484.3 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 19,015.9 мянган төгрөгийн түвшинээс 5,468.4 мянган төгрөгөөс их байх боловч илүү гарсан дүнгийн үр дүн санхүүгийн тайлан дахь нөлөөлөл бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 7,574.4 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Бараа материалын дансанд 7 672.4 мянган төгрөгийн хөрөнгийн шинж чанартай тавилга, тоног төхөөрөмж бүртгэлтэй байна.
- Бараа материалын дансыг хангамжийн материал, аж ахуйн материал, хоол хүнс, тусгай зориулалтын материал, эм бэлдмэл зэргээр ангиладаггүй бараа материал гэсэн нэрээр нэг хоёр дансанд бөөнд нь бүртгэдэг байна.

8.2 Төлбөрийнакт

Тайлангийн хугацааны эцэст нийт 800.0 мянган төгрөгийн гүйлгээ ө баримтгүй анхан шатны баримтын бүрдэлгүй хийгдсэн байна.

8.3 Албаншаардлага

Байгууллагын автомашинуудын километрийн спидометр ажилладаггүй явсан км тодорхойгүй тооцоо бодолт, шатахууны тайлан хангалтгүй байна. Шатахууны зарцуулалтад хяналт тавих боломжгүй. Автомашины явсан км-ыг жолоочийн амаар тооцдог байна. Жнь: 51-80 БУЛ улсын дугаартай авто машины километрийн заалтанд биет байдлаар тулгалт хийхэд жолоочийн тооцооны хуудсан дахь километрийн заалтаас 985км-ын зөрүүтэй байна.

Төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлээгүй, замчдын баярын арга хэмжээнд 2 565.8 мянган төгрөг, тэмцээн уралдаанд 930.0 мянган төгрөг, оны эцэст баярын арга хэмжээнд 2 135.5 мянган төгрөг, шагнал урамшуулалд 3 400.0 мянган төгрөг олгосон байна.

Тайлангийн хугацааны эцэст нийт 12 227.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл, 590.0 мянган төгрөгийн дансны өглөг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Мөн Төрийн өмчийн хорооны тогтоолоор Куветын сангаас 17 нэр төрлийн машин механизм, тоног төхөөрөмжийг УХЗээлээр авч одоог хүртэл шийдвэрлэгдэхгүй 565 211.3 мянган төгрөг балансад өглөгөөр бүртгэгдэн олон жил болсон байна зэрэг зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тогооч Б.Халиунаагийн 8 сарын цалин 630.0 мянган төгрөгөөс 163.8 мянган төгрөгийн НДШ тооцоогүй нийгмийн даатгалд тайлагнаагүй байгаа нь “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 17.1.1-т “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтын зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ажилчдын цалинг нийгмийн даатгалд бүрэн хамруулж нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тооцон тайлагнаж байх.

2. Цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Гүүр арчилагч 4 ажилтны ажилласан хугацааны 1 589.4 мянган төгрөгийн ээлжийн амралтыг бодож олгоогүй байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1. Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно гэсэн заалтын зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ажилчдын амралтыг бүрэн, үнэн зөв тооцоолох

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа 4 нэр төрлийн 209 437.4 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС үндсэн хөрөнгө 17-ийн 49 Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай " гэсэн заалтын дагуу дахин үнэлгээ хийх шийдвэрийг гаргуулан дахин үнэлгээг хийлгэн санхүүгийн тайланд тусгаж байх гэсэн заалтыг зөррчиж, оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа хөрөнгийг заавар журмын дагуу актлуулах саналыг гаргуулан актлаж устгах, стандартын дагуу дахин үнэлгээг хийж бодит үнэ цэнээр тайланд тусгах.

4. Цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлангийн хугацааны эцэст ажилчдын цалингаас тооцсон ХХОАТ-ын хөнгөлөлтийг 44.0 мянган төгрөгөөр илүү, 74.7 мянган төгрөг дутуу суутгасан байгаа нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт 0-6 сая хүртэл 240000,6-12 сая хүртэл 216000 төгрөг хөнгөлнө гэсэн заалтыг зөрчиж,нийцсэн бөгөөд зохистой байх. батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цалингийн хугацааны эцэст ХХОАТ-ын мэдээг татаж тайланг тулган хөнгөлөлтийг тааруулж тайлагнах

5. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансанд тайлангийн хугацаанд 170 мэдээ мэдээллэхээс 168-ийг мэдээлж 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг зөрчиж, толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хуулийн дагуу шилэн дансны мэдээллийг хугацаанд нь үнэн зөв тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ :




Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Д.АНХБАЯР



